

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 17

### ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАНЫ НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ ЖУРАМ, ЗАГВАР БАТЛАХ ТУХАЙ

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.12, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсгийг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Төрийн жинхэнэ албан тушаал эрхэлж байгаа албан хаагчийн нөөцийн бүртгэл хөтлөх загвар”-ыг 2 дугаар хавсралтаар, “Ерөнхий шалгалт өгч тэнцсэн иргэний нөөцийн бүртгэл хөтлөх загвар”-ыг 3 дугаар хавсралтаар, “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаал эрхэлж байсан удирдах албан тушаалтны нөөцийн бүртгэл хөтлөх загвар”-ыг 4 дүгээр хавсралтаар, Төрийн жинхэнэ албан тушаалаас чөлөөлөгдсөн албан хаагчийн болон иргэний нөөцийн бүртгэл хөтлөх загвар”-ыг 5 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн “Журам батлах тухай” 99 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэхүү журмын хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба, Салбар зөвлөлд тус тус даалгасугай.

ДАРГА

Б.БААТАРЗОРИГ

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны

17 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

### ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАНЫ НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ ЖУРАМ

#### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Төрийн жинхэнэ албан тушаал эрхэлж байгаа албан хаагч, төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалт өгч тэнцсэн иргэн, Төрийн албаны тухай хуулийн 16.3, 46.1-д заасан албан хаагчдаас төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх харилцааг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол энэ журмаар зохицуулна.

1.2. Төрийн жинхэнэ албаны нөөцийн сан (цаашид “нөөцийн сан” гэх)-г Төрийн албаны зөвлөл эрхэлнэ.

1.3. Нөөцийн сан нь төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн бүрэлдэхүүн хэсэг мөн.

#### Хоёр. Нөөцийн сангийн бүрэлдэхүүн

2.1. Нөөцийн сан нь доор дурдсан бүрэлдэхүүн хэсэгтэй байна:

2.1.1. **төрийн жинхэнэ албан тушаал эрхэлж байгаа** албан хаагчийн нөөц;

2.1.2. **төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалт өгч тэнцсэн** иргэний нөөц;

2.1.3. **төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах** албан тушаал эрхэлж байсан албан хаагчийн удирдах албан тушаалтны нөөц;

2.1.4. Төрийн албаны тухай хуульд заасны дагуу **төрийн жинхэнэ албан тушаалаас түр чөлөөлөгдсөн** албан хаагчийн нөөц;

2.1.5. Төрийн албаны тухай хуулийн **62.1.4-т заасан болон Цэргийн алба хаагчийн** эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу цэргийн тэтгэвэр тогтоолгож /дээдофицер, офицер, ахлагч/ төрийн жинхэнэ албан тушаалаас чөлөөлөгдсөн иргэний нөөц;

2.1.6.эрх бүхий байгууллагын шийдвэрээр нөхөр /эхнэр/ нь өөр **орон нутаг, гадаад улс, олон улсын байгууллагад шилжин ажиллах болсон**, эсхүл гэр бүлийн хүнд өвчтэй аль нэг гишүүнээ асрах зайлшгүй шаардлагын улмаас төрийн жинхэнэ албанаас чөлөөлөгдсөн албан хаагчийн нөөц;

2.1.7.төрийн зардлаар **их, дээд сургуульд суралцуулж төгссөн иргэн** /цэрэг, цагдаа, тагнуул, онцгой байдал, шүүхийн шийдвэр, шүүх шинжилгээ, хилийн болон дотоодын цэрэг г.м/-ий нөөц.

### **Гурав. Нөөцийн сангийн бүртгэл, хөдөлгөөн**

3.1.Төрийн жинхэнэ албаны нөөцийн бүртгэл, хөдөлгөөнийг дараах байдлаар хөтөлнө:

3.1.1.нөөцийн сангийн нэгдсэн бүртгэл, хөдөлгөөнийг Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба;

3.1.2.энэ журмын 2.1.2, 2.1.3, 2.1.7-д заасан нөөцийн бүртгэл, хөдөлгөөнийг Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба, бусад нөөцийн бүртгэл, хөдөлгөөнийг харьяалах Салбар зөвлөл;

3.1.3.салбар зөвлөлгүй төрийн байгууллагын нөөцийн бүртгэл, хөдөлгөөнийг тухайн байгууллага.

3.2.Нөөцийн бүртгэл, хөдөлгөөнийг батлагдсан загварын дагуу хөтөлнө.

3.3.Төрийн албаны тухай хуулийн 62.1.4-т заасан үндэслэлээр төрийн жинхэнэ албан тушаалаас чөлөөлөгдсөн албан хаагчийг бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн нөөцөд бүртгэнэ.

3.4.Салбар зөвлөл болон төрийн байгууллага нь төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн бүртгэл, хөдөлгөөнд өөрчлөлт орсон мэдээг Төрийн албаны зөвлөлийн Ажлын албанд тухай бүр ирүүлэх үүрэгтэй.

3.5.Салбар зөвлөл нь нөөцийн бүртгэл, хөдөлгөөний тайланг тухайн оны 7 дугаар сарын 1, дараа оны 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор гаргаж Төрийн албаны зөвлөлийн Ажлын албанд хүргүүлнэ.

3.6.Салбар зөвлөлгүй төрийн байгууллага нөөцийн бүртгэл хөдөлгөөний тайланг энэ журмын 3.5-д заасан хугацаанд Төрийн албаны зөвлөлийн Ажлын албанд хүргүүлнэ.

3.7.Бүх шатны төрийн байгууллага нь нөөцийн бүртгэл, хөдөлгөөнд орсон өөрчлөлтийн мэдээг харьяалах Салбар зөвлөлд тухай бүр ирүүлнэ.

3.8.Төрийн албаны зөвлөл, Салбар зөвлөл энэ журамд заасан харьяалаар нөөцөд бүртгэж, нөөцийн санг бүрдүүлнэ.

### **Дөрөв.Нөөцөд байх хугацаа**

4.1.Энэ журмын 2.1.2, 2.1.6, 2.1.7-д заасан иргэн, төрийн жинхэнэ албанаас чөлөөлөгдсөн албан хаагчийн нөөцөд байх хугацаа **3 жил** байна. Энэ журмын 2.1.6-д заасан нөөцөд байх хугацааг уг шалтгаан арилснаас эхлэн тооцно.

4.2.Энэ журмын 2.1.3-2.1.5-д заасан нөөцөд байх хугацаа хуульд өөрөөр заагаагүй бол тэтгэвэр тогтоолгох насанд хүрснээр дуусгавар болно.

4.3.Зөвхөн хуульд заасан үндэслэлээр иргэнийг нөөцийн сангийн бүртгэлээс хасна.

### **Тав. Нөөцийн сангийн мэдээллээр хангах**

5.1.**Төрийн байгууллага, албан тушаалтны албан ёсны хүсэлтээр нөөцийн санд хамаарах мэдээллээр** Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба, Салбар зөвлөл хангаж, энэ тухай бүртгэл хөтөлнө.

### **Зургаа.Бусад**

6.1.Холбогдох хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэж төрийн албанаас халсан, чөлөөлсөн, огцруулсан иргэнийг нөөцийн санд бүртгэхгүй.

**ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ТУШААЛ ЭРХЭЛЖ БАЙГАА АЛБАН ХААГЧИЙН НӨӨЦИЙН БҮРТГЭЛ**

Д/ д	Ажиллаж байгаа				Албан хаагчийн мэдээлэл										Нөөцөд бүртгэсэн шийдвэрийн огноо, дугаар	Нөөцөс хассан тухай тэмдэглэл	
	Байгууллагын нэр	Нэгжийн нэр	Албан тушаалын нэр	Ангилал, зэрэглэл	Эцэг /эх/-ийн нэр	Өөрийн нэр	Төрсөн огноо	Хүйс	Регистрийн дугаар	Боловсрол /Хэзээ, хаана, ямар сургуульд өгссөн/	Мэргэжил	Мэргэшл /мэргэшлийн багц сургалтад хамрагдаж төгссөн гэрчилгэний дугаар/	Төрийн албан тушаалд ажилласан байдал				
													Ангилал	зэрэглэл			Зэрэгдэв
1																	
2																	
3																	

Бүртгэл хийсэн:

..... /...../

(албантушаал)                      (гарынүсэг)                      (гарын үсгийн тайлал)

.....

(огноо)

**ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАНЫ ЕРӨНХИЙ ШАЛГАЛТ ӨГЧ ТЭНЦСЭН ИРГЭНИЙ НӨӨЦИЙН БҮРТГЭЛ**

Д/д	Иргэний мэдээлэл								Шалгалтын дүн				Нөөцөд бүртгэсэн шийдвэрийн огноо, дугаар	Нөөцөөс хассан тухай тэмдэглэл	
	Эцэг (эх) - ийн нэр	Өөрийн нэр	Төрсөн огноо	Хүйс	Регистрийн дугаар	Боловсрол /Хэзээ, хаана, ямарсургуультагссээн/	Мэргэжил	Шалгалт өгсөн		Ерөнхий мэдлэг	Монгол хэл, бичгийн чадвар	Дүн шинжилгээ хийх чадвар			Нийт дүн
								Байршил	Огноо						
1															
2															
3															

Бүртгэл хийсэн:

..... /...../

(албантушаал)                      (гарынүсэг)                      (гарын үсгийн тайлал)

.....

(огноо)

**ТӨРИЙН ӨНДӨР АЛБАН ТУШААЛТНЫ ЗЭРЭГ ЗИНДАА, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ТӨРИЙН АЛБАН ТУШААЛТНЫ ЗЭРЭГЛЭЛД ХАМААРАХ АЛБАН ТУШААЛ  
ЭРХЭЛЖ БАЙСАН АЛБАН ХААГЧИЙН УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНЫ НӨӨЦИЙН БҮРТГЭЛ**

Д/ д	Ажиллаж байсан			Иргэний мэдээлэл										Нөөцөд бүртгэсэ н шийдвэр ийн огноо, дугаар	Нөөцө өс хассан тухай тэмдэг лэл	
	Байгууллагы ннэр	Албан тушаа лын нэр	Ангил ал, зэрэг лэл	Эцэг /эх/ ийнн эр	Өөри йн нэр	Төрс өн огно о	хү йс	Регистрийнд угаар	Боловсрол /Хэзээ, хаана, ямарсургуульта гссөн/	Мэргэ жил	Төрийн албанд ажилласан байдал					Албан тушаалаа с чөлөөлөг дсөн хуулийн үндэслэл, огноо, шийдвэр
											Ангил ал	зэрэг лэл	Зэр эг дэв			
1																
2																

Бүртгэл хийсэн

..... /...../

(албантушаал) (гарынүсэг) (гарын үсгийн тайлал)

.....

(огноо)

**ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАНААС ЧӨЛӨӨЛӨГДСӨН АЛБАН ХААГЧИЙН БОЛОН ИРГЭНИЙ НӨӨЦИЙН БҮРТГЭЛ**

Д/Д	Ажиллаж байсан				Иргэний мэдээлэл									Албан тушаалаас чөлөөлөгдсөн хуулийн үндэслэл, огноо, шийдвэр	Нөөцөд бүртгэсэн шийдвэрийн огноо, дугаар	Нөөцөөс хассан тухай тэмдэглэл		
	Байгууллагын нэр	Нэгжийн нэр	Албан тушаалын нэр	Ангилал зэрэглэл	Эцэг (эх) - ийн нэр	Өөрийн нэр	Төрсөн огноо	Хүйс	Регистрийн дугаар	Боловсрол /Хэзээ, хаана, ямар сургууль төгссөн/	Мэргэжил	Мэргэшил /мэргэшлийн багц сургалтад хамрагдаж төгссөн гэрчилгээний дугаар/	Төрийн албанд ажилласан байдал					
													Ангилал	зэрэглэл	Зэрэг дэв			
Журмын 2.1.4-т заасан нөөц																		
1																		
Журмын 2.1.5-д заасан нөөц																		
1																		
Журмын 2.1.6-д заасан нөөц																		
1																		
Журмын 2.1.7-д заасан нөөц																		
1																		

Тайлбар: Нөөцийн бүртгэлийг төрийн жинхэнэ албан тушаалаас түр чөлөөлөгдсөн, чөлөөлөгдсөн байдлыг хуулийн үндэслэлээр ангилан хийнэ.

Бүртгэл хийсэн:..... /...../  
 (албантушаал) (гарынүсэг) (гарын үсгийн тайлал)